



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/327

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.6, 6.2, 17 дугаар зүйлийн 17.1.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Нэгдүгээрт хүүхэд” Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэн шинжлэх ухаан, урлаг, спортын өөрийн сонирхсон төрөл, чиглэлд онцлох амжилт гаргасан хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх, амжилт ололтыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Хүүхэд нас-амжилт бахархал” уулзалт, арга хэмжээг зохион байгуулан, дэмжлэг үзүүлж урамшуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг Засаг дарга дансны “Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүдийн зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

